

Таван талх хоёр загас

-Five Loaves & Two Fish-



42Page

Тайлбарлагч Есүс Галил нуурын нөгөө захад сургаал зааж байв. Есүсийн тухай сонссон хүмүүс, Түүний байгаа газарт ихээр ирж байв. Тиймээс хүмүүсийн дундуур явж байхдаа, өвчтэй хүн байвал эдгээж, тэдэнд тэнгэрийн хаанчлалын тухай ярьж өгөв. Орой бүрийн болох үед дагалдагч нар нь Есүс дээр хүрч ирээд хэлсэн нь:

Дагалдагч1 Энэ олон хүмүүсийг яах вэ?

Дагалдагч2 Энэ газар хотоос зайдуу учир харанхуй болохоос өмнө хүмүүсийг ойрхон тосгоны буцааж оройн хоолыг нь идүүлвэл ямар вэ?

Тайлбарлагч Тэр үед Есүс ингэж хэлэв.

Есүс Тэд хол явах хэрэггүй. Харин та нар тэдэнд идэх хоол өг.

Дагалдагч1 Есүс ээ, бидэнд мөнгө ч байхгүй, мөнгө байлаа ч хоолны газар энд алга шүү дээ. Гэхдээ бид яаж ийм олон хүнийг хооллож чадах билээ?

.....

Тайлбарлагч Дагалдагч нар нь шалгаж мэдээд Есүст хэлэв.

Дагалдагч2 Нэгэн бяцхан хүүд таван талх хоёр загас байна.

Есүс Тэгвэл түүнийг нь аваад ир.

Тайлбарлагч Дагалдагч нар хүү дээр очиж хэлэв.

Дагалдагч Чи өөртөө байгаа идэх юмыг Есүст өгж чадах уу?

Хүү Тэгэлгүй яахав, би Есүст өгье.

Тайлбарлагч Хүү өөртөө байгаа таван талх хоёр загасыг дагалдагч нарт өгөв.

.....

Тайлбарлагч Дагалдагч нар таван талх хоёр загасыг Есүст өгөв. Есүс цугласан хүмүүсийг тавь тавиар нь хувааж суулгав. Тэнд ирсэн нийт эрчүүдийн тоо гэхэд л 5000 орчим болж байлаа. Есүс таван талх хоёр загасыг гартаа барин өргөөд залбирсны дараагаар хэлсэн нь:

Есүс Одоо хүмүүст хувааж өг.

Тайлбарлагч Гэтэл гайхалтай зүйл болжээ. Хичнээн хувааж өгсөн ч талх ба загас дуусахгүй байв.



43Page



44Page



45Page

Тайлбарлагч Тэнд цугласан бүх хүн гэдэсээ дүүртэл хангалттай идэж цадав. Хүмүүс Есүсийн хүч чадлыг шагшин магтаж байв. Есүс дагалдагч нартаа дахин хэлэв.

Есүс Идэж дуусаад илүү гарсан хоолыг хаялгүйгээр бүгдийг сагсанд хийгээрэй.

Дагалдагч За энд илүү гарсанаа хийгээрэй.



46Page

Тайлбарлагч Гэтэл идэж дуусаад илүү гарсан хүнс 12 сагс болсон байв. Есүсийг дагаж байсан дагалдагч нар болон бусад хүмүүс Есүст илүү итгэн Түүнийг хүндэтгэн дагажээ.